

Сэдэв: Олон улсын ТЭЭВЭРЛЭЛТ





Бараа бүтээгдэхүүнийг ямар нэгэн тээврийн хэрэгсэл ашиглан нэг газраас нөгөөд зөөж шилжүүлэх үйлдлийг тээвэрлэлт гэж ойлгоно.


Түүнчлэн бараа бүтээгдэхүүнд шаардлагатай тээврийн хэрэгслийг сонгосноор харилцагчийнхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, зардлаа хэмнэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх зэрэг олон чухал ач холбогдолтой.

Олон улсын ачаа тээвэрлэлт нь хоёр болон түүнээс дээш тооны улсын хил боомтыг дамжин явагддаг учраас өөр өөр эрх зүйн, улс төрийн, газар зүйн, технологийн, цаг хугацааны, байгалийн давагдашгүй хүчин зүйл зэрэг маш олон нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай тулгардаг.

Жишээлбэл: Монгол улсад мөрдөгддөг хууль, журам зөвхөн Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилдэг бол хил давснаас хойш тухайн улсын хууль журмыг дагаж мөрдөх хэрэгтэй болдог.



- Тохирсон тээврийн хэрэгслийг сонгох нь тодорхой зорилгод буюу таны ачааг аюулгүй, цаг хугацаанд нь хүргэх чадвартай, нийт зардал нь хамгийн бага байх тээврийн хэрэгслийг сонгоно гэсэн үг юм.
- Экспортлогч ямар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаагаас хамаараад тухайн барааны шинж чанар буюу жин, овор хэмжээ, хадгалалтын онцгой нөхцөл, сав баглаа, үнэ зэрэг онцлогыг харгалзан тээврийн хэрэгслээ сонгох шаардлагатай тулгардаг.



Агаарын тээвэрлэлт:

- Богино хугацаанд харьцангуй хол зайнд түргэн хүргэх шаардлагатай барааг хүргэж нийлүүлэхэд давуу талтай.
- Өртөг зардал өндөр, бага хэмжээний ачаа тээдэг, цаг агаарын нөхцөл байдал шууд нөлөөлдөг зэрэг сул талтай.



Авто замын тээвэрлэлт:

- Ердийн буюу тусгайлсан зам шаардалгүй хүлээх авагчийн байгаа газар барааг шууд хүлээлгэн өгөх, хэрэглэгчийн хүссэн янз бүрийн хэмжээ, хэлбэрээр барааг тээж хүргэх боломжтой.



- Харин харьцангуй өндөр үнэтэй, нэг удаагийн тээвэрлэлтээр харьцангуй бага ачаа тээдэг нь сул тал болдог.

Далайн тээвэрлэлт



Дамжуулах хоолойн тээвэрлэлтийг эс тооцвол хамгийн хямд өртөг зардлаар, их хэмжээний барааг тээвэрлэдэг, тусгайлсан зам бэлтгэх шаардлагагүй зэрэг давуу талуудтай.

Харин тээвэрлэх явц удаан, бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн явцад эвдэлж гэмтээх магадлалтай зэрэг сул талтай.



Төмөр замын тээвэрлэлт:

- Хуурай газрын тээвэрлэлтүүдийн дотор их хэмжээний барааг нэг дор тээвэрлэх чадвартай бөгөөд цаг агаарын нөлөөлөл бараг байхгүй нь энэ төрлийн тээвэрлэлтийн давуу тал болдог.
- Гэвч анх барьж байгуулахад их хэмжээний зардал гардаг, зөвхөн тусгайлан зориулсан замаар л тээвэрлэлтийг хийдэг зэрэг сул талтай.





Дамжуулах хоолойн тээвэрлэлт:

- Хамгийн хямд тээвэрлэлт гэж үздэг. Гэвч энэ хэлбэрээр зөвхөн тухайлан заагдсан барааг буюу нефть, шатдаг хий гэх мэтийг л тээвэрлэнэ.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

